

**“АЛСЫН ХАРАА–2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО 2020-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН  
/ НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗАР/**

2024 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дун	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7

**ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ**

Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.

Хүрэх үр дун: 9. Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлнэ.

37	9.2.13. Авто тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэн, агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг орон сууцжуулах асуудлыг шат дараатай, системтэй хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулна.	2020 -2050	-	-	<p>2024 оны жилийн эцсийн байдлаар төвийн зургаан дүүргийн нутаг дэвсгэрт 16 байршил 41 хэсэгчилсэн талбайд 38 тесөл хэрэгжүүлэгч гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 20,247 айлын орон сууц ашиглалтад оруулсан бөгөөд 3,404 нэгж талбарын газар чөлөөлөлт хийгдсэн. Төслийн гадна инженерийн шугам сүлжээний зураг тесөл, барилга угсралтын ажилд 2024 онд нийслэлийн төсвээс 19.3 тэрбум төгрөг, нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 52.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр тусгасан.</p> <p>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Сэлбэ дэд төв орчмын 158 га талбай, Баянхшуу дэд төв орчмын 162 га талбай, Сэлбэ дэд төв орчмын хоёрдугаар ээлжийн 733 га талбай, Дамбадаржаа дэд төв орчмын 71.8 га талбай, Толгойт дэд төв орчмын 133.3 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоосон.</p> <p>Нийслэл хотын хүн амын хэт төвлөрлийг сааруулах нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх, орчны бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд 6-н дэд төвийн хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн ажлууд хийгдэж байна. Сэлбэ болон Баянхшуу дэд төвийн инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил 2023 онд 100 хувь хийгдэж дуусган бөгөөд 20'000 айлыг хангах гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Дамбадаржаа дэд төвийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 50 хувь, Толгойт дэд төвийн гүйцэтгэл 40 хувь, Дэнжийн мянга дэд төвийн гүйцэтгэл 7.6 хувь Шархад дэд төвийн гүйцэтгэл 11 хувийн хэрэгжилттэйгээр дэд бүтцийн бүтээн байгуулалт үргэлжилж байна.</p> <p>Сэлбэ дэд төв орчмын 158.0 га талбайд нийт 2206 нэгж талбар хамрагдаж байгаа бөгөөд хөрөнгийн үнэлгээний хэмжилт хийгдэж,</p>	90%
----	--	------------	---	---	---	-----



					<p>үнэлгээ баталгаажсан 1238 нэгж талбарт 234.1 тэрбум төгрөгийн нөхөх олговрыг Нийслэлийн Засаг даргын 21 удаагийн захирамжаар шийдвэрлэсэн байна.</p> <p>Сэлбэ дэд төвийг түшиглэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн эхний ээлжийн 13 га талбайн барилга угсралтын ажлын тендерийг зохион байгуулж, 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр нээсэн. Тендерийг нийт 13 га талбайд хоёр багц дээр зохион байгуулсан бөгөөд багц тус бүрт хоёр оролцогч компани тендерийн материал ирүүлсэн байна. Эхний ээлжийн 13 га талбайд 10 блок есөн давхар орон сууц, 8 блок таван давхар орон сууц, 960 хүүхдийн сургууль, 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгуудыг барихаар төлөвлөсөн.</p> <p>Гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлэх байршилууд болох Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооноы зураг төсвийн ажил боловсруулгадж, магадлалын ерөнхий дүгнэлт гарсан. Монгол улсын болон нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулахаар саналыг хургуулсэн.</p>	
Зорилт 9.3. Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжих байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжине.						
Хүрэх үр дүн: 2. Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамж нэмэгдсэн байна.						
68	9.3.3. Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	2020-2050	-	10287	<p>Батлагдсан гэр хорооллын газрын дахин төлөвлөн барилгажуулах төслийн 26 байршил 83 хэсэгчилсэн талбай нь нийт 1,661.9 га талбай, 20,798 нэгж талбарыг хамарч байна. Тус байршилуудад батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 148,323 айлын орон сууц, 60 сургууль, 92 цэцэрлэг, 14 эмнэлгийг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. 2024 оны жилийн эцсийн байдлаар төвийн зургаан дүүргийн нутаг дэвсгэрт 16 байршил 41 хэсэгчилсэн талбайд 38 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллын газрын дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 20,247 айлын орон сууц ашиглалтад оруулсан бөгөөд 3,404 нэгж талбарын газар чөлөөлөлт хийгдсэн. Төслийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажилд 2024 онд нийслэлийн төсвээс 19.3 тэрбум төгрөг, нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 52.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр тусгасан. 2024 онд 2659 айлын орон сууц ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажилласан бөгөөд нийт 2014-2024 онд өссөн дунгээр 20247 айлын орон сууц ашиглалтад орсон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Баянгол дүүргийн 10, 11 дүгээр хороо Б хэсэгчилсэн талбай Очирияа пропрети деделодмент ХХК 239 айлын орон сууц,</li> <li>- Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хороо А хэсэгчилсэн талбайд Баганат өргөө ХХК 342 айлын орон сууц,</li> <li>- Б хэсэгчилсэн талбай Гангар инвест ХХК 180 айлын орон сууц,</li> <li>- Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо Дарь Эх орчимд төсөл хэрэгжүүлэгч Магма од ХХК 230 айлын орон сууц,</li> </ul>	90%

146

					<ul style="list-style-type: none"> <li>- Баянзүрх дүүрэг 13, 14 дүгээр хороо Г хэсэгчилсэн талбай Бүрд констракшн ГХДТ ХХК 194 айлын орон сууц,</li> <li>- Д хэсэгчилсэн талбай Шинэ гэр түншлэл ХХК 115,</li> <li>- Ё хэсэгчилсэн талбай Ай Энд жи интернэшил ХХК 150 айлын орон сууц,</li> <li>- Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо А хэсэгчилсэн талбай Бүргэд констракшн ХХК 105 айлын орон сууц,</li> <li>- Б хэсэгчилсэн талбай Жигүүр гранд групп ХХК 160 айлын орон сууц,</li> <li>- В хэсэгчилсэн талбай Батхэрэйд ХХК 96 айлын орон сууц,</li> <li>- Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо Н хэсэгчилсэн талбайд төсөл хэрэгжүүлэгч И ПИ СИ ЭМ Монголия ХХК 224 айлын орон сууц,</li> <li>- Б хэсэгчилсэн талбай Пример инвестиент групп ХХК 108 айлын орон сууц,</li> <li>- Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо Е хэсэгчилсэн талбай Андын зам констракшн ХХК 120 айлын орон сууцыг тус тус ашиглалтад оруулсан.</li> </ul> <p>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Сэлбэ дэд төв орчмын 158 га талбай, Баянхошуу дэд төв орчмын 162 га талбай, Сэлбэ дэд төв орчмын хоёрдугаар ээлжийн 733 га талбай, Дамбадаржаа дэд төв орчмын 71.8 га талбай, Толгойт дэд, төв орчмын 133.3 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоосон.</p> <p>Сэлбэ дэд төв орчмын 158.0 га талбайд нийт 2206 нэгж талбар хамрагдаж байгаа бөгөөд хөрөнгийн үнэлгээний хэмжилт хийгдэж, үнэлгээ баталгаажсан 1238 нэгж талбарт 234.1 тэрбум төгрөгийн нэхөх олговрыг Нийслэлийн Засаг даргын 21 удаагийн захирамжаар шийдвэрлэсэн байна.</p> <p>Сэлбэ дад төвийг түшиглэн гар хорооллыг орон сууцжуулах төслийн эхний ээлжийн 13 га талбайн барилга угсралтын ажлын тендерийг зохион байгуулж, 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр нээсэн. Тендерийг нийт 13 га талбайд хоёр багц дээр зохион байгуулсан бөгөөд багц тус бүрт хоёр оролцогч компани тендерийн материал ирүүлсэн байна. Эхний ээлжийн 13 га талбайд 10 блок есөн давхар орон сууц, 8 блок таван давхар орон сууц, 960 хүүхдийн сургууль, 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгүүдүг барихаар төлөвлөсөн.</p>	
66	9.3.4. Олон төрлийн (орлогод нийцсэн, түрээсийн, ногоон) орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, 150,000 айлын орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2020-2050	Дахин төлөвлөлтийн зураг төсөл 1,254.8 Инженерийн шугам сүлжээ, барилга угсралт 4,843.1		<p>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/237 дугаар захирамжаар гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд хийгдэх гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн 4 ажилд 612.2 сая төгрөг батлагдсан бөгөөд зураг төсөл боловсруулах зөвлөх үйчилгээний ажилд захиалагчийн хяналтыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ тавьж ажиллаж байна.</p> <p>Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 2014-2024 оны байдааар 76 шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил хийгдсэн байна.</p> <p>1. Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2024-2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XII.4.3-д "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн 4 байршил 8 хэсэгчилсэн талбайн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсвийн 2,380,809.4 тэрбум төгрөг суудсан Барилга хот байгуулалтын яам худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.</p>	90%

66

			<p>2. 2024 онд улсын төсвөөс 8 хэсэгчилсэн талбайд 744,870.5 сая төгрөг гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийн төсөв олгоно. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтанд Нийслэлийн засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/164 захирамжаар Гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажлын нийт 37,189.1 сая суулгахаас 15,000.0 тэрбум төгрөгийн 9 ажлыг он дамжсан төсөв санхүүжилт суудсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Баянзүрх дүүрэг 12-р хороо, 2,426.8 тэрбум төгрөг</li> <li>2. Чингэлтэй дүүргийн 13, 15-р хороо, 465.8 сая төгрөг</li> <li>3. Баянгол дүүргийн 10 дугаар хороо, 2,335.3 тэрбум төгрөг</li> <li>4. Баянгол дүүргийн 11, 22 дугаар хороо, 2,644.9 тэрбум төгрөг 2023 онд батлагдсан хөрөнгө болох 633.1 /сая төгрөг/</li> <li>5. Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, 2,404.6 тэрбум төгрөг</li> <li>6. 14 дүгээр хороолол, 2,774.8 тэрбум төгрөг</li> <li>7. 14-р хорооллын Бохир усны: 1,208.2 тэрбум төгрөг</li> <li>8. Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороо, 239.6 сая төгрөг</li> <li>9. Туул дэд станц Дунжингарав дэд станцаас Дэчинравжайлин хийдийн урд тал хуртлэх цахилгаан хангамжийн шугам сүлжээний нэвтрэх сувгийн зураг төсөл барилга угсралтын ажил нийт 3.787.9 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд 2024 онд олгогдох санхүүжилт 500.0 сая төгрөг суудсан.</li> </ol>	
	<p>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр</p>	<p>Баянхошуу дэд төвд баригдах 126 айлын орон сууцны барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан.</p>	<p>"Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл" AHURP Улаанбаатар хотын ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, хотыг цэцэрлэгжүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд Баянхошуу дэд төвийн эхний эзлжийн эко хорооллын төлөвлөлтэд 70 ширхэг мод, 37 ширхэг бут сөөг болон 7927 м2 ногоон байгууламж төлөвлөн зураг төслийн ажлыг гүйцэтгэж, бүрэн дуусгасан. Шархад дэд төвийн эхний эзлжийн эко хорооллын төлөвлөлтэд, 11000 м2 зүлэгжүүлэлтийн талбай төлөвлөн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Ингэснээр тус төслийн эко хорооллын нийт талбайн 25%-ийг ногоон байгууламж эзэлж байна.</p> <p>Төслийн бодлогын шинэчлэл хийх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 1-р үе шатны нарийвчилсан ТЭЗҮ, нарны эрчим хүчний ТЭЗҮ-ийг тус тус боловсруулж, эко хорооллын төлөвлөлтийн гарын авлага, техникийн шаардлагуудыг тусгасан баримт бичгүүдийг боловсруулсан. Ногоон орон сууцны нарийвчилсан ажлын жишиг зурагт төслийн тогтвортой хөгжлийн 37 шалгур үзүүлэлтүүдийг (KPI) тусган, олон улсын ногоон барилгын үнэлгээний EDGE систем, Монгол улсын Барилгын норм ба дүрэмд нийцүүлэн боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагууд болон магадлалаар хянуулж батлуулсан.</p> <p>Төслийн 1-р үе шат буюу 2023-2026 онуудад Баянхошуу болон Шархад дэд төвүүдэд нийт 800 өрхийн ногоон орон сууц бүхий эко хорооллуудын цогц бүтгэн байгуулалтыг гүйцэтгэх бөгөөд эхний эзлжийн 220 өрхийн ногоон орон сууцны барилга угсралтын ажил 2024 дуусаж ашиглалтад орно. Харин үлдсэн 520 айлын ногоон орон сууц бүхий эко хорооллын барилга угсралтын ажлыг 2024-2026 онуудад үе шаттайгаар гүйцэтгэнэ</p>	70%

841

				Явган хүний болон унадаг дугуйн зам барьж байгуулах, өргөтгөх, нүхэн, гүүрэн гарцыг нэмэгдүүлж хяналтын системийг бий болгох ажлын хүрээнд Баянхошуу дэд төвийн эхний ээлжийн эко хорооллын төлөвлөлтэд 4200 м явган зам талбай, нэг урсгалтай, 1.5м өргөн 1780 м2 ундааг дугуйн зам төлөвлөн зураг төслийн ажлыг гүйцэтгэж дууссан ба барилга угсралтын ажлыг 2023-2025 онуудад үе шаттай гүйцэтгэж байна.	
	Европын Сэргээн босголтын хөгжлийн банкны санхүүжилтээр			<p>"Ханын материал орчмын 712 айлын орлогод нийцсэн ногоон орон сууц төсөл" Европын Сэргээн босголт, хөгжлийн банк болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байгуулсан "Улаанбаатар хотын ногоон орон сууц" төслийн зээлийн хэлэлцээрийн ажлын хэсэгт орж, мэдээллээр тогтмол хангаж ажиллаж байна. Төслийн зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын хурлаар 2023 оны 05 сарын 31-ний өдөр хэлэлцсэн.</p> <p>Төслийн хэрэгжилтэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 2023 онд зохион байгуулж, үнэлгээний хорооны дүгнэлтийг НЭДТГ-ын дарга баталгаажуулан ЕСБХБанкруу 4 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн. ЕСБХБ-аас 6 дугаар сарын 5-ны өдөр баталгаажуулсан. Шалгарсан зөвлөх компанийт хэлэлцээр хийж, гэрээ байгуулах ажлын хэсгийг НЭДТГ-ын даргын 5 дугаар сарын 31-ний А/134 тоот тушаалаар байгуулсан ба бэлтгэл ажлыг хангах хүрээнд ажлын даалгавар болон бусад баримт бичгийг төслийг боловсруулсан ба төслийн хэрэгжилтэд шаардлагатай бусад судалгаа, мэдээлэл бэлтгэн өгч байна. 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр "GREEN ENGINEERING KZ LLP" -тай 24350243 тоот Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Зөвлөх үйлчилгээний компанийт 2023 оны 9 сарын 20-ны өдөр онлайн хурлыг зохион байгуулсан ба Төслийн гарын авлага, төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц зэргийг яаралтай боловсруулан Эхлэлийн тайлангийн хамт хүргүүлэх хугацааг тодорхойлж ирүүлэхийг НЭДТГ-аас хүссэний хариуд тайланг ирүүлэхээр зөвлөх компаниас мэдэгдэл ирсэн.</p> <p>2023 оны 10 сарын 19-ний өдөх зөвлөх үйлчилгээ үзүүлэх "GREEN ENGINEERING KZ LLP" тай хамт Төслийн талбай дээр очиж нөхцөл байдалтай танилцсан багаад тухайн өдөр тус төслийн оролцогч талуудын уулзалтыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газар дээр зохион байгуулж, төслийн хэрэгжилт төлөвлөлтийн талаар санал солилцсон. Мөн уулзалтын хүрээнд Архитектур төлөвлөлтийн даалгавар, олгогдсон Техникийн нөхцөлүүд, Төслийн талбай байрлах нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон бусад холбогдох материал солилцсон.</p> <p>"GREEN ENGINEERING KZ LLP"-тай хамтран ажиллаж төслийн загвар зураг боловсруулсан, батлуулах ажил хийгдэж байна.</p> <p>Төслийн нэгжийн гарын авлага, төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоо батлуулах ажлын хүрээнд төсөл хэлбэрээр боловсруулж, НЭДТГазарт хүргүүлж батлуулсан. Төслийн нэгж байгуулах ажлын хүрээнд 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр төслийн нэгжийн албан хаагчдыг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлсэн. Хэрэгжилт 50%</p>	

				<p>"Баянголын амны 2007 айлын түрээсийн болон түрээслээд өмчлөх орон сууцны хороолол төсөл"</p> <p>БНСУ-ын Экспорт-Импортын банк болон Сангийн яам хооронд 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Зээлийн гэрээ байгуулагдсан. Тус зээлийн гэрээний хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 34-р хороонд байрлах 10га газарт Баянголын амын орлогод нийцсэн ногоон орон сууц төслийг хэрэгжүүлэхээр болсон ба төслийн санхүүжилтээр 2-3 өрөө бүхий 2007 айлын орон сууц, машины зогсоол болон нийтийн эзэмшилийн тохиижилтэн ажлууд хийгдэхээр төлөвлөгдсэн.</p> <p>Төслийн нийт дүн 114.7 сая доллар ба төслийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, захиалагчийн хяналт тавих, төсөл хэрэгжүүлэх хугацаанд хэрэгжүүлэгч байгууллагад дэмжлэг үзүүлэх Зөвлөх үйлчилгээний компаниар БНСУ-ын Аум ба Лий түншлэл сонгогдож 2021 оны 9 сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулсан. Төслийн удирдах хорооны 2 дугаар хурлыг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж төслийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус баталсан.</p> <p>Төслийн нарийвчилсан зураг, төсөв боловсруулан магадлангаар оруулж 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дүгнэлтээр баталгаажуулсан. 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр төслийн иж бүрэн зураг төсөл, тендерийн эцэслэн материалыг хүлээж авсан.</p> <p>Барилга угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах хүрээнд төслийн талбайн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, Нийслэлийн байгаль орчны газраар баталгаажуулахаар хүргүүлсэн. Мөн БНСУ-ын Экспорт-Импортны саналыг тендерийн бичиг баримтын төсөлд тусган дахин боловсруулж 2023 оны 04 дугаар сарын 13-ны өдөр тендер зарлах зөвшөөрөл авахаар хүргүүлсэн. Төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Төслийн барилга угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Нийслэлийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн A/1457 тоот захирамжаар байгуулж 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн A/91 тоот захирамжаар шинэчилсэн. Үнэлгээний хорооны хурлыг 10 удаа зохион байгуулсан бөгөөд Төслийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулах тендерийг 2023 оны 06 сарын 21нд зарлаж, 2023 оны 08 сарын 09нд нээж үнэлэх ажлыг эхлүүлсэн.</p> <p>Төслийн чадавх нэмэгдүүлэх 4 удаагийн сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 16-30-ны өдруүдэд БНСУ-д зохион байгуулж, 8 албан хаагчийг хамруулснаар нийт 40 албан хаагч сургалтад хамрагдаж чадавх нэмэгдүүлэх бүхэлдэхүүн ажлын дуусгасан.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импорт банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Баянголын амын орлогод нийцсэн орон сууц төсөл"-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн A/20 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь "Баянголын амын орлогод нийцсэн орон сууцны төсөл"-ийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг 2024 оны 03 сарын 01-ний өдөр зарласан. Тендерийн үнэлгээний ажил хийгдэж НЗДТГ-т Эксим банкаар батлуулсан үнэлгээний тайланг хүргүүлсэн. "Баянголын амын орлогод нийцсэн орон сууц төсөл" орон сууцны хорооллыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж НЗДТГ-т тушаалаар Гэрээний хэлэлцээр хийх</p>
--	--	--	--	---

					<p>ажлын хэсэг байгуулагдаж ажлын хэсэг нийт 6,7 сард 5 удаагийн хурал, "ИЛ СОНГ" ХК-тай 4 удаагийн хэлэлцээр хийж 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулсан.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос улсын Экспорт-Импорт банканд гэрээг EDCF дүрэм журмын дагуу хянан баталгаажуулж өгөх албан тоот илгээсэн. Экспорт-Импорт банкнаас 2024 оны 08 дугаарын сарын 14 өдөр ирсэн зөвлөмжийн дагуу гэрээний өөрчлөлт хийсэн. Гэрээний нэмэлт өөрчлөлт 2024 оны өдрийн 08 дугаар сарын 29-ний өдөр баталгаажсан. Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 10 га талбайд 2007 айлын орон сууцны хороолол барих төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажил хангагдаж байна. Хэрэгжилт 70%</p>	
			<p>Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилт - \$344.2 сая, зарцуулалт - \$158.03 сая</p>	-	<p>"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл (GADIP)"</p> <p>Төслийн 1 дүгээр үе шатны хүрээнд: Баянхошуу, Сэлбэ дэд төвийн инженерийн дэд бүтцийн болон нийгмийн барилга байгууламжийн ажлын бүрэн дуусгасан</p> <p>Төслийн 2 дугаар үе шатны хүрээнд: Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүдийн нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд зураг төсөл боловсруулалтын ажил дууссан. Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 97%. Худалдан авах ажиллагааны явц 76%. Дэд төвүүдийн нийт барилга угсралтын ажлын явц 37% байна. Энэ үе шатны хэрэгжилтийн явц 56%-тай байна.</p> <p>Төслийн 3 дугаар үе шатны хүрээнд: Шархад, Толгойт дэд төвүүдийн газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 94.4%. Худалдан авах ажиллагааны явц 35.8%. Зураг төсөл боловсруулалтын ажлын явц 73.5%. Барилга угсралтын ажлын явц 11.5%. Энэ үе шатны хэрэгжилтийн явц 33%-тай байна. Хэрэгжилт 70%</p>	-
67	9.3.47. Хот дахин төлөвлөлтийн хүрээнд гэр хорооллыг төвлөрсөн, хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамжид холбон сэргээгдэх эрчим хүчийг ашиглана.	2021- 2030	-	-	<p>Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу, Дамбадаржаа, Дэнжийн мянга, Толгойт, Шархад дэд төвүүд, Хүрээ загвар цогцолбор гудамж болон Газар шинэчлэн зохион байгуулах төслийн батлагдсан талбаруудад зохион байгуулагдаж буй хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, холбогдох ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг нь Нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн A/677 дугаар захирамжаар байгуулагдсан. Гэр хорооллыг төвлөрсөн инженерийн хангамжид хангах төсөлд нийт 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 22 төсөл хэрэгжүүлэгчид 50 блок 5684 айлын орон сууцыг барьж ашиглалтад хүлээлгэн өглөө. Хэсэгчилсэн болон бие даасан хангамжаар хангах Дэд бүтцийн төв төсөл нь 3 байршилд хэрэгжсэн, Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороонд хэрэгжсэн Дэд бүтцийн төв нь 100 хувь хэрэгжиж дуусган, 162 айл өрхийг хэсэгчилсэн инженерийн хангамжаар хангасан. Цаашдын ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Сэргээгдэх эрчим хүчний технологи ашиглан хэрэгжүүлэх гэр хорооллын захын бүсийн дахин төлөвлөлтийн хүрээнд Хайбрид хауз ХХК-тай хамтран ажиллах гэрээг НОСК ХК байгуулан, тодорхой тооны гэр хорооллын алслагдсан бүсийн айл өрхийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	90%

/81

				<p>Гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх "Дэд бүтцийн төв" төслийг хэрэгжүүлэх дараах 3 байршилд ажлын зураг төслийг боловсруулах ажлыг Эм Эл ХХК гүйцэтгэж, магадлал хийгдсэн. Гүйцэтгэл 100%</p> <p>1.Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, 2.Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, 3.Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороо</p> <p>Гэр хорооллын дундын бүсэд 200-300 айл өрхийг хэсэгчилсэн инженерийн дэд бүтцээр хангах "Дэд бүтцийн төв" төслийг хэрэгжүүлж, иргэдийн амины орон сууцны дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр дараах байршуудад ажиллаж байна. Үүнд:</p> <p>1."Дэд бүтцийн төв" төслийн хамгийн эхний загвар төслийг Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрийн 220 нэгж талбарыг хамарсан 14 га газарт амжилттай хэрэгжүүлж, байнгын ашиглагч байгууллагад хүлээлгэж егсэн.</p> <p>2.Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороонд БХБЯ-ны санхүүжилтээр хэрэгжих буй Бичил дэд төв төслийн эхний ээлжийн цэвэр ус, цахилгааны шугам, 25x18x7,8 м хэмжээтэй 2 давхар барилга угсралтын ажил 100% угсралдаж дууссан бөгөөд 2 дугаар ээлжийн бохир усны шугамын барилга угсралтын ажил 50%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.</p> <p>3.Налайх дүүргийн 1 хороонд хэрэгжих буй Дэд бүтцийн төв төслийн ажлын явц нь 95%-тай улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хангаж байна.</p> <p>Багахангай дүүрэг 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр тус дүүрэгт хэрэгжүүлэх Дэд бүтцийн төв төслийн зураг төсөл боловсруулж, батлуулсан. Монгол улсын 2024 оны төсөв Багахангай дүүрэг хэрэгжүүлэх Дэд бүтцийн төв төслийн 14.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгөөс 4.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан. Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус ажлын гүйцэтгэгийг сонгон шалгаруулах нээлттэй тендер зохион байгуулагдсан бөгөөд ГЦЦЭ ХХК шалгарч, 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр гэрээ байгуулах эрх олгогдсон. Улс, нийислэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө болон төсөвт тусгуулахаар саналыг хүргүүлсэн болно</p>	
--	--	--	--	---	--

Хэрэгжилтийн дундаж: 86%

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ж.БОЛОРТУЯА

О.АРИУНЖАРГАЛ

78